

Зарим компанийн брокер, дилерийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1."Ажнай инвест" ХХК, "Мөнхөд" ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбоотойгоор энэ тогтоолын 1-д заасан компаниудын анхан шатны баримт бичгүүдийг хүлээлцэх ажлыг зохион байгуулах комиссыг "Монголын хөрөнгийн бирж" ХК, "ҮЦТТХТ" ХХК, тусгай зөвшөөрөл хүчингүй болсон компанийн зохих төлөөллийг оролцуулан яаралтай байгуулахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын 1-д заасан компаниудын харилцагчдыг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад компанид шилжүүлэх ажлыг 2008 оны эхний хагаст багтаан зохион байгуулахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

4.Дурдсан компаниудын тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тухай нийтэд мэдээлж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ